

## **ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.10-т “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтын 44-т даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хасах, даатгалын хохирол үнэлгээний эрх зүйн орчныг холбогдох хуультай уялдуулах, салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог хангах, даатгуулагч, даатгагчийн эрх ашгийг хамгаалах, тэнцвэржүүлэх хүрээнд мэргэжлийн оролцогчийн зарим үйл ажиллагааг хязгаарлах зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж тусгасан байдаг.

Иймд Монгол Улсад даатгалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх зүйн байдлыг оновчтой болгох, даатгалын үйлчилгээг хэрэглэгчдэд мэргэжлийн түвшинд хүргэх, хүлээх үүрэг хариуцлагыг хуульчилж тодорхой болгох хэрэгцээ шаардлагын дагуу Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 10 бүлэг, 52 зүйлтэй бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагааг сайжруулах, практикт тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэх замаар салбарын хөгжлийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх бодлогыг баримталж дараах өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

**Нэгдүгээр бүлэгт**, ямар харилцааг зохицуулах талаар буюу хуулийн зорилт, хууль тогтоомжийн бүрдэл буюу зохицуулах хууль тогтоомжууд болон хуулийн нэр томъёог тусгасан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэсэн нэр томъёог “Даатгалын зуучлалын тухай хууль” болгож өөрчилсөнтэй холбоотойгоор 1 дүгээр зүйл буюу “Хуулийн зорилт”, 2 дугаар зүйл буюу “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж”-д холбогдох өөрчлөлт орсон. 3 дугаар зүйл буюу “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт”-ын “даатгалын мэргэжлийн оролцогч”, “даатгалын төлөөлөгч”, “даатгалын зуучлагч”, “гадаадын мэргэжлийн оролцогч”-ийг шинэчлэн найруулж, “банк-зуучлагч”, “даатгалын зуучлалын үйл ажиллагаа”, “даатгалын бүтээгдэхүүн”, “хамтын даатгал” болон “холбогдох этгээд”-ийн нэр томъёоллыг шинээр тусгасан.

Хуулийн төсөлд дурдагдсан зарим нэр томъёоны тайлбарыг доорх хүснэгтэд харуулав.

| Нэр томъёо                                           | Нэр томъёоны үүсэл                                                                        | Гол утга                                                                                                     |
|------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|
| Банк-зуучлагч буюу<br>Банкашурэнс<br>/Bancassurance/ | 1970 онд Франц улсад<br>Credit Mutuel, Credit Agricole<br>банкууд анх ашиглаж<br>эхэлсэн. | Банкны сувгийг ашиглан банкны<br>харилцагчдад нь даатгалын<br>бүтээгдэхүүн хүргэх талаар<br>хамтын ажиллагаа |
| Брокер<br>/Broker/                                   | Франц хэлний brocour буюу<br>үүргийн худалдаачин гэсэн<br>утгатай үг.                     | Даатгуулагч болон даатгагчийн<br>хооронд холбон зуучлагч                                                     |

Мөн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг Даатгалын тухай хуулиар зохицуулахтай холбоотойгоор “даатгалын хохирол үнэлэгч” нэр томъёо болон холбогдох зохицуулалтыг, “Зохицуулах хороо”-г өөр аргачлалаар хуулийн төсөлд тусгасан тул хуулийн нэр томъёоноос тус тус хассан.

Даатгалын олон улсын зарчимд мэргэжлийн оролцогч гэдэгт амьдралын, ердийн, давхар даатгалын компаниуд мөн даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч, актуарч, андеррайтер, аудитын компаниудыг хамааруулдаг. Гэтэл өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд эдгээрээс зөвхөн даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг даатгалын мэргэжлийн оролцогчид хамааруулсан бөгөөд бусад мэргэжлийн оролцогчдын талаарх зохицуулалт, эрх, үүрэг энэхүү хуулиар тодорхойгүй байх тул “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэсэн нэр томъёог “Даатгалын зуучлалын тухай хууль” болгож даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт буюу даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийн эрх зүйн харилцааг олон улсын туршлагад нийцүүлэн илүү ойлгомжтой тодорхой тусгаснаар олон нийт болон салбарт оролцогчдын төөрөгдөл, буруу ойлголтыг багасгана.

Монгол Улсад даатгалын салбарын хөгжил хангалттай бус байгаа нь нэг талаас иргэдийн даатгалд итгэх итгэл, ойлголт хангалтгүй, нөгөө талаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг даатгагчид мэргэжлийн түвшинд тайлбарлаж ойлгуулах, мэдээлэл хангалттай өгч чадахгүй байгаатай холбон тайлбарлаж болохоор байна. Олон улсын жишгээр даатгалын салбар дах дундын зуучлагчид нь олон нийтэд даатгалын талаарх зөв ойлголтыг түгээх, талуудын эрх ашгийг тэнцвэржүүлэхэд чухал үүрэг нөлөөтэй байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооны захиалгаар Эн-Ар-Си-Си судалгааны агентлагаас санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийг үнэлэх, иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог судлах зорилгоор улсын хэмжээнд 1000 гаруй иргэдийг хамруулан, санамсаргүй түүврийн аргаар хийсэн “Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”<sup>1</sup> -ны үр дүнгээс харвал олон нийт, даатгуулагчдын даатгалын тухай мэдлэгийг сайжруулах, даатгалын хэрэгцээгээ зөв

<sup>1</sup> “Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн итгэлийн судалгаа”, Эн-Ар-Си-Си судалгааны агентлаг, 2019

үнэлэх, даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгцээ шаардлагадаа тохируулан оновчтой сонголт хийх түүнчлэн тэдний даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай, ийнхүү нэмэгдүүлэхэд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн үүрэг оролцоо маш чухал болох нь тодорхой харагдаж байна.

Олон улсад даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа нь даатгалын компанийн нөхөн төлбөр олгох үйл ажиллагааны нэг хэсэгт хамаардаг бөгөөд даатгалын компанийн ажилтан хохирлыг тооцох нийтлэг хандлага байдаг. Манай улсын хувьд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа нь Даатгалын тухай хуулиас тусдаа Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулагдаж, тус хуулийн дагуу заавал тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд хохирол үнэлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь даатгуулагчийн хувьд цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн хүндрэл учруулдаг байсан тул олон улсын чиг хандлагад нийцүүлэн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг Даатгалын тухай хуулиар зохицуулж, хохирол үнэлэх ажлыг даатгалын компанийн ажилтан хийж гүйцэтгэх, даатгуулагч үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд эсхүл үнэлгээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд хөндлөнгийн хохирол үнэлэгчээр үнэлүүлэх эрх зүйн нөхцөл орчныг бүрдүүлсэн.

**Хоёрдугаар бүлэгт,** Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зохицуулах хорооны бүрэн эрх болон үйл ажиллагааг зохицуулах журмуудын талаар тусгасан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд “ЗГ-ыг даатгалын зуучлалын бодлогын зөвлөгөөгөөр хангах” гэсэн заалт нэмсэн. Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхэд “даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл олгох түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих” гэсэн заалтуудыг нэмж, бусад бүрэн эрхийг шинэчлэн найруулсан.

- Мөн 6 дугаар зүйл буюу “Даатгалын журам”-ыг шинэчлэн тусгаж, 7 дугаар зүйл буюу “Даатгалын мэргэжлийн оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны журам” зүйлийг хассан.

Даатгалын тухай хуульд заасанчлан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг уялдуулсан ба төрийн захиргааны төв байгууллага нь тусгайлсан хуулиуд, үйл ажиллагааны талаар Засгийн Газрыг байнга бодлогын зөвлөгөөгөөр ханган ажилладаг тул энэхүү заалтыг тусгасан. Мөн даатгалын төлөөлөгчид тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг больж энгийн зөвшөөрөл олгох зохицуулалттай болгож байгаатай холбоотойгоор даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой бүрэн эрхийг нэмж тусгасан.

Даатгалын зуучлалын үйл ажиллагааг зөвхөн даатгалын багц дүрмээр зохицуулахгүй бусад дүрэм журмаар зохицуулахаар байгаа тул зүйлийн нэрийг өөрчлөн тусгасан бөгөөд журмуудыг үйл ажиллагаагаар нь багцлан журамлахаар тусгасан. “Даатгалын мэргэжлийн оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны журам”-д

заасан зохицуулалтууд нь Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэхээр байгаа тул шаардлагагүй заалтууд тул хуулиас тус зүйлийг хассан.

**Гуравдугаар бүлэгт**, зөвшөөрлүүдийн төрөл болон зөвшөөрөл хүсэх, олгохтой холбогдсон зохицуулалтууд, гадаадын даатгалын брокер, хамтын даатгалд оролцох, цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, засаглалын тогтолцоо болон даатгалын төлөөлөгчтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- “Даатгалын зуучлагчийн эрх, үүрэг” зүйл шинээр тусгаж, даатгалын брокерын үйл ажиллагааг ердийн даатгалын брокер, амьдралын даатгалын брокер, давхар даатгалын брокер гэж ангилан, даатгалын брокер болон банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт, бүрдүүлэх баримт бичгүүдийг тусгасан.

- Мөн зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах нөхцөл, зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, зөвшөөрөл эзэмшигчид тавих хязгаарлалт, гадаадын даатгалын брокерын үйл ажиллагаа, хамтын даатгал, цахим хэлбэрээр даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх болон засаглалын тогтолцоотой холбоотой зохицуулалтуудыг тусгасан.

- Мөн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг нэг даатгагчийг төлөөлөх энгийн зөвшөөрлийг иргэнд болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх энгийн зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох зохицуулалтыг тусгаж, бүрдүүлэх бичиг баримт, зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох талаар тусгасан.

Даатгалын зуучлагч нь мэргэжлийн түвшинд даатгуулагчийн ашиг сонирхол нийцэхүйц гэрээ, хэлцлийг байгуулах, эрсдэлийг шилжүүлэх үйл ажиллагааг хөндлөнгөөс зохион байгуулж байгаа этгээд болох тул даатгуулагчийн эрсдэл, ашиг сонирхлыг сайтар судалж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой. Мөн даатгалын зуучлагч нь харилцагчаа хохироосон, мэргэжлийн бус буруутай үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх шаардлага, хэм хэмжээг хуулиар нарийвчлан зааж өгөх шаардлага үүссэн. Иймд даатгалын зуучлагч нь даатгуулагч, харилцагчид тохирох даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд даатгагчдын талаар мэдээллээр хангах, эрэлт хэрэгцээ шаардлагыг нь нарийвчлан тодруулсны үндсэн дээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, хэлцэлд зуучлах зэргээр мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлэх нийтлэг үүрэгтэй байх, түүнчлэн үйлчилгээний доод стандартыг тодорхой болгох, хэрэгжүүлэх хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоог хангах боломжтой байна. Хуульд даатгалын төлөөлөгч, зуучлагчийн үүрэг хариуцлагыг тодорхой тусгаагүйгээс <sup>2</sup> даатгагч, даатгуулагчийн хоорондын гэрээ ойлгомжгүй, хоёрдмол утгатай хийгдэх,

---

<sup>2</sup> Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд даатгалын төлөөлөгчийн эрх үүрэг болон даатгалын зуучлагчийн эрх үүрэг байдаггүй.

ингэснээр даатгуулагчийн эрх ашиг зөрчигдөх зэрэг сөрөг үзэгдлүүд гарах эрсдэлийг бий болгож байгаа тул даатгалын зуучлагчийн эрх, үүргийг тодорхой болгож тусгасан.

Даатгалын зуучлалын үйл ажиллагааг даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгч гэсэн 3 этгээд хэрэгжүүлэх бөгөөд даатгалын брокер нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, банк-зуучлагчийн үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсан банк, харин даатгалын төлөөлөгч нь нэг даатгагчийг төлөөлөх тохиолдолд иргэн, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх тохиолдолд хуулийн этгээд байх бөгөөд Хорооноос энгийн зөвшөөрөл авсан байх зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн даатгалын зуучлалын үйл ажиллагааг илүү мэргэшсэн, төрөлжүүлсэн байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд даатгалын брокерын үйл ажиллагааг ердийн даатгалын брокер, амьдралын даатгалын брокер, давхар даатгалын брокер гэж 3 ангилсан.

Олон улсын судалгаанаас харахад “Bancassurance” буюу банк, даатгалын компанийн хамтын үйл ажиллагаа, даатгалын дундын зуучлалтай холбогдох шинэ нэр томьёо бий болж, даатгалын зуучлагч, төлөөлөгчдөөс ялгаатай байдлаар зохицуулж, тавигдах шаардлага, борлуулах бүтээгдэхүүн, үйлчилгээнд хязгаарлалт тавьж зохицуулсан байдаг байна. Түүнчлэн банк даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлснээр дараах үр ашгийг даатгалын салбарт үзүүлэх боломжтой байдаг. Үүнд:

- ✓ Даатгалын компанийн салбар, төлөөлөгч байхгүй орон нутаг дахь алслагдсан аймаг, сумдад банкууд нь өөрийн салбаруудаар дамжуулан даатгалын зуучлалын үйл ажиллагааг даатгуулагч иргэдэд хүргэж, даатгалын салбарын борлуулалтын суваг өргөжих;
- ✓ Даатгалын компанийн орон нутаг дахь үйл ажиллагааны зардлыг бууруулах, цаашлаад даатгалын хураамжийг бууруулах;
- ✓ Банкаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нарт банкны болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дороос хүргэх.

Давхар даатгалын үйл ажиллагаанд даатгалын зуучлагч илүү мэргэшсэн байх практик шаардлагатай тул даатгалын брокерын үйл ажиллагааг төрөлжүүлснээр давхар даатгалын брокерт тавигдах шаардлага тодорхой болж журмаар зохицуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн хамтарсан даатгалын үйл ажиллагаанд даатгалын брокерын оролцох эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Даатгалын олон улсын тулгуур зарчим /ICP/-тай уялдуулан даатгалын брокер болон банк-зуучлагч нь үйл ажиллагаагаа найдвартай, оновчтой удирдлагаар хангаж, бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, цогц байдалд нийцэх үр дүнтэй засаглалын тогтолцоог бий болгож, мөрдөж ажиллахаар тусгасан бөгөөд даатгалын брокер болон банк-зуучлагчийн засаглал, мэдээллийн ил тод байдал, мэргэжлийн ёс зүйтэй байдал нэмэгдсэнээр иргэд, олон нийт даатгалын салбарт итгэх итгэл нэмэгдэнэ.

Мөн даатгалын зуучлагчийн эрх бүхий албан тушаалтан болон гадаадын даатгалын брокер нь Хорооноос зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг тусгасан.

Монгол Улсад 2019-2023 оны хооронд даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын дунджаар 34.0 хувь буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зарцуулан, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг авсан ба дээрх валютын гадагшлах урсгалыг дотоодын зах зээлд шингээх бололцоог хууль, эрх зүйн бодлогын түвшинд тусгах шаардлагатай байна<sup>3</sup>. Үүний тулд нэг талаас дотоодын давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх, нөгөө талаас даатгагчдыг хамтран ажиллах таатай эрх зүйн орчныг бий болгох, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн “хамтын даатгал”-ын зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр дотооддоо даатгалын хураамжийн хэмжээг өсгөх боломж бүрдэх ба эдгээрийг Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төсөлд мөн тусгаж байгаа билээ. Энэхүү харилцаанд даатгалын зуучлагчдын оролцоо мөн чухал үүрэгтэй учраас даатгалын зуучлагч нь даатгалын үнэлгээ ихтэй даатгалын гэрээг зуучлахад нэг даатгагч дангаар даатгах боломжгүй тохиолдолд дараагийн даатгагчид хамтрах саналыг гаргахыг үүрэг болгох, гадаадын даатгагчтай шууд зуучлахыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, дотоодын даатгагчдыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх боломжтой байгааг харгалзан үзэх боломжтой байна.

Аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр эрхэлж болохоор тусгасан. Тус эрх зүйн орчныг бүрдүүлснээр даатгалын зуучлагчийн үйл ажиллагааны зардал буурах, борлуулалтын суваг нэмэгдэх, даатгалын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх, түүнчлэн иргэд даатгалын үйлчилгээг авахад илүү хялбар болох боломж бүрдэнэ.

Ихэнхи улс орнуудад, тухайлбал Герман, Австрали, Япон, Белги, Франц, Итали, Мексик, Нидерланд, Португал, Испани, Швейцарь, Их Британи, Сингапур, Солонгос, Кени улсуудын жишээгээр даатгалын төлөөлөгчийг зохицуулах байгууллагад бүртгүүлж, тавигдах шаардлагыг тусгаж, үйл ажиллагаандаа баримтлах хэм хэмжээг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал, даатгалын төлөөлөгч нь өөрийн төлөөлж байгаа даатгагчийг заавал дурдах буюу аль даатгагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгааг даатгуулагчид мэдэгдэх, мөн даатгагчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулж байгаагийн хувьд гэрээ байгуулахтай холбогдон үүсэх хариуцлагыг зөвшөөрөл олгосон даатгагч дангаар хариуцахаар тодорхой зохицуулсан байдаг нь манай зохицуулалтаар бол тавигдах шаардлагуудыг хангасан тохиолдолд энгийн зөвшөөрөл олгодог зохицуулалттай ижил байдаг.

---

<sup>3</sup> Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын 2016-2023 оны 4-р улирлын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгуудаас шаардлагатай тоон мэдээллүүдийг түүвэрлэж, боловсруулав. <https://frc.mn/data/tailan?c=310> холбоосоор харна уу.

Иймд даатгагчийн албан ёсны зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын төлөөлөгчид Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгож байгаа нь төрд ачаалал үүсгэсэн, даатгалын төлөөлөгчид чирэгдэл учруулан ач холбогдолгүй, зохицуулалтын хувьд шаардлагагүй зохицуулалт болоод байгаа тул олон улсын туршлагад нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл авах заалтыг хасаж Хорооноос энгийн зөвшөөрөл авдаг байхаар зохицуулж, даатгалын төлөөлөгчийн нэр томьёог уялдуулан өөрчилж, холбогдох зохицуулалтыг шинэчилсэн.

**Дөрөвдүгээр бүлэгт**, даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа шилжүүлэхэд тавих хяналттай холбоотой зохицуулалтууд тусгагдсан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- Даатгалын брокер, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотой зохицуулалтыг өөрчлөн найруулсан.
- Хувьцаа шилжүүлэхэд тавих хяналтын талаар зохицуулалтыг шинээр тусгасан.

Даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэх, хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглох, хувь нийлүүлсэн хөрөнгийн заасан хэмжээнд хүрэхгүй эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай бүрд Хороонд мэдэгдэж, бүртгүүлэх талаар тусгасан. Мөн даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалахад хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх, хувьцаа эзэмшигч этгээд нь Хорооноос баталсан тохиромэтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх шаардлагуудыг тавьсан. Ингэснээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эцсийн өмчлөгчийг тогтоох боломжтой болно.

**Тавдугаар бүлэгт**, нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх, жил бүрийн санхүүгийн тайлан, улирал тутмын тайлан болон даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтууд тусгагдсан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- Даатгалын брокер, банк-зуучлагч болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргахаар тусгасан.
- Жил бүрийн болон улирал тутмын тайлан тушаах хугацааг тодорхой болгосон.
- Даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх бөгөөд санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдтэй холбогдох харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулахаар тусгасан.

Даатгалын брокер, банк-зуучлагч, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч санхүүгийн тайлан гаргах, тайлагнах зохицуулалтыг шинэчлэн найруулсан. Мөн нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх, жил бүрийн санхүүгийн тайлан, улирал тутмын тайлангийн зохицуулалтыг шинэчлэн найруулж тусгасан. Даатгалын брокер, хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгч нь санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх болон холбогдох харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулах, аудит хийх хуулийн этгээд нь тайлан дүгнэлтийг даатгалын брокер болон хэд хэдэн даатгагчийг төлөөлөх төлөөлөгчид хүргүүлэх талаар зохицуулалтыг тусгасан.

**Зургаадугаар бүлэгт,** даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа, төлбөр, хөлс, хураамж болон түүнд тавигдах хязгаарлалт, мэдээллийг өөрчлөх талаар зохицуулалтыг шинэчлэн найруулсан.

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд Монголын даатгалын зуучлагчдын холбооноос ирүүлсэн саналд “Даатгуулагч болон түүний эрх бүхий этгээд нь даатгагчаас нөхөн төлбөр авахаас бусад тохиолдолд аливаа хөлс, шагналыг шууд болон бусад этгээдээр дамжуулан авахгүй байх” гэж Даатгалын тухай хуульд нэмж оруулсан заалтын тухайд “Энэ саналыг дэмжиж байна. Даатгал хөгжихгүй байгаа шалтгаануудын нэг нь энэ юм.” гэсэн байна.

Иймд даатгалын гэрээ байгуулахад зуучлагч, төлөөлөгч нь даатгалын хураамжаас бусад хэлбэрээр аливаа мөнгөн шагнал урамшууллыг авах, даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөрөөс бусад хэлбэрээр гэрээ байгуулсны төлөө шан харамж авах зэргийг зөрчилд тооцох шаардлагатай байна. Даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг тэнцвэржүүлэх үүднээс даатгалын зуучлагч нь даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг үйлчлүүлэгч зөвшөөрсөн болон Хорооноос зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж байгаа хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглосон. Мөн Хороо шаардлагатай тохиолдолд даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болох зохицуулалтыг тусгасан.

Даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсэж байгаа этгээд нь Хороонд ирүүлсэн баримт материалд өөрчлөлт орвол нэн даруй мэдэгдэх үүрэгтэй байхаар тусгасан.

**Долоодугаар бүлэгт,** зах зээлийн зохистой үйл ажиллагаа, төөрөгдүүлсэн зар сурталчилгаатай холбоотой зохицуулалтууд тусгагдсан бөгөөд дараах шинэчилсэн найруулгыг тусгасан. Үүнд:

- Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаанд оролцогч болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүнийг дагаж мөрдөх талаар тусгасан.



- Мөн даатгалын зуучлагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглосон бөгөөд хэрэв зөрчсөн тохиолдолд Хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, залруулахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгах талаар зохицуулалтыг тусгасан.

**Наймдугаар бүлэгт,** “Үйл ажиллагааны хяналт шалгалт”, “Хяналт шалгалттай холбоотой этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг”, “Шалгалтын тайлан”, “Хорооны мэдээлэл цуглуулах эрх” болон “Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх”-ийг шинэчлэн найруулж, “Нэгдсэн хяналт шалгалт”-ыг шинээр тусгасан.

Хороо даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг холбогдох даатгалын журмын дагуу хэрэгжүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд тохирох мэргэшсэн, дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулах эсвэл зарим чиг үүргээ тухайн чиглэлээр мэргэшсэн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болох талаар болон Хорооны авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зохицуулалтуудыг тусгасан.

Даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээд шалгалт хийхтэй холбоотой хүлээх үүрэг болон Хороо хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад шаардлагатай мэдээлэл, тайлбарыг шалгалтад хамрагдах этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас аливаа хэлбэрээр авч болохоор тусгасан.

Хороо үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 өдрийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлэх болон шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан, эсхүл албан шаардлага өгсөн бол шалгалтад хамрагдсан этгээд тайлан, албан шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор, эсхүл тэдгээрт тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй байх болон шалгалтын тайлан тусгах зүйлсийн талаар зохицуулалт тусгасан.

Хорооны тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл, баримт бичгийг даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээдээс шаардаж, шаардлага тавьж болох талаар тусгасан бөгөөд даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээдийн хүлээх үүргийн талаар тусгасан.

Хороо гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэхдээ анхаарах асуудлууд, гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэх болон туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэлүүдийн талаар тусгасан.

Мөн Хороо холбогдох төрийн байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх, түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох харилцааг зохицуулах болон

холбогдох этгээд Хорооны шаардсан мэдээллийг гаргаж өгөх талаар зохицуулалтыг тусгасан.

**Есдүгээр бүлэгт,** даатгалын брокер, банк-зуучлагчийн зохицуулалттай холбоотойгоор албадлагын арга хэмжээ авах үндэслэл, төрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, даалгавар, шалгагчийг томилоход өөрчлөлт орж, “Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгосноос үүсэх үр дагавар”-ыг шинээр тусгасан.

Даатгалын зуучлагчид төлбөрийн чадваргүй болох асуудал байхгүй тул “даатгалын зуучлагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл” гэсэн албадлагын арга хэмжээ авах үндэслэлийг хасаж, даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулаагүй тохиолдолд албадлагын арга хэмжээ авах үндэслэл болох талаар зохицуулалтыг нэмж тусгасан.

Мөн зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө Хороо Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагаа явуулах талаар болон зөвшөөрөл эзэмшигч нь уг ажиллагаатай холбоотой мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар тусгасан.

Хороо даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авахдаа байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох агуулга бүхий даалгаврыг улсын байцаагчийн албан шаардлагаар өгөх зохицуулалтыг нэмж тусгасан. Мөн Хороо албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилох, ямар асуудлыг хянан шалгах талаар зохицуулалтыг тусгасан.

Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгалын зуучлагч Хорооноос өгсөн зөвшөөрөлгүйгээр шинээр даатгалын гэрээ байгуулах, зуучлах, шинэчлэх, өөрчлөхийг хориглосон бөгөөд шаардлагатай тохиолдолд даатгалын зуучлагч холбогдох зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх талаар зохицуулалтыг тусгасан.

**Аравдугаар бүлэгт,** даатгалын зуучлагчид гомдол гаргах болон гомдол хянан шийдвэрлэх зохицуулалтыг шинээр тусгаж, мөн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх зохицуулалтыг шинэчлэн найруулсан.

Даатгуулагч даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотойгоор эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзвэл даатгалын зуучлагчид гомдол гаргах бөгөөд даатгалын зуучлагч уг гомдлыг шийдвэрлэх хугацааг тодорхой болгож заасан. Мөн шийдвэрийг даатгуулагч зөвшөөрөхгүй тохиолдолд Хороонд гомдол гаргах эрхтэй болон гомдол гаргах хугацааг тусгасан.

Тус хуулийн дагуу зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн маргааныг Хороо урьдчилан шийдвэрлэх талаар зүйл тусгасан. Мөн хэрэв арбитрын хэлэлцээртэй бол

даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгасан.

Мөн уг мэдээллийн нууцлалыг хадгалах, Хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлагыг шинэчлэн найруулсан.

Хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ямар этгээдүүдийн аливаа мэдээллийг задруулахыг хориглох талаар болон Хорооны албан хаагч, бусад этгээд энэхүү хуулийг зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг зааж тусгасан.

---oOo---